



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 10 өдөр.

Дугаар 350

Улаанбаатар хот

Удирдах хороог шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёрдах хөтөлбөр", "Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар, орон нутгийн салбар хорооны удирдах бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэнд, спортын яамны төрийн нарийн бичгийн дарга, Удирдах хорооны дарга /Ганчимэг/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 426 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081240

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 09 сарын 10 өдрийн
350 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



**Нэг. Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг
Удирдах хорооны бүрэлдэхүүн**


Дарга	Эрүүл мэнд спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга
Орлогч дарга	Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал
Нарийн бичгийн дарга	Эрүүл мэнд спортын яамны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
	Хавдар судлалын үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга
	Эрүүл мэнд спортын яамны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
	Эрүүл мэнд спортын яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга
	Эрүүл мэнд спортын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
	Эрүүл мэнд спортын яамны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
	Эрүүл мэнд спортын яамны Эм, эмнэлгийн хэлтсийн дарга
	Эрүүл мэнд спортын яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
	Хавдар судлалын үндэсний төвийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл эрхэлсэн дэд захирал
	Хавдар судлалын үндэсний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
	Хавдар судлалын үндэсний төвийн стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал
	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал

Эмгэг судлалын үндэсний төвийн захирал
Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга
Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал
Халдварт өвчин судлалын үндэсний төвийн
Дархлаажуулалтын албаны дарга
Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал

ДЭМБ-ын халдварт бус өвчний асуудал хариуцсан
мэргэжилтэн (зөвшилцсөнөөр

Итгэл хавдаргүй монгол ТТБ-ын тэргүүн
(зөвшилцсөнөөр).

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 09 сарын 10 өдрийн
350 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



**Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг Удирдах хорооны
үйл ажиллагааны удирдамж**

Нэг. Ерөнхий чиг үүрэг

- 1.1 Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, олон улсын болон гадаад орны төрийн ба төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны шугамаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- 1.2 Бодлого, үйл ажиллагаанд тулгамдсан асуудлын талаар санал боловсруулан шийдвэрлүүлэх
- 1.3 Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндэсний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, тусалцаа үзүүлэх
- 1.4 Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах
- 1.5 Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах үүрэг бүхий техникийн ажлын хэсэг байгуулж үйл ажиллагаанд хяналт тавих

Хоёр. Ажиллах журам


- 2.1 Удирдах хороо жилд 2-оос доошгүй удаа хуралдана.
- 2.2 Шаардлагатай үед ээлжит бус хурлыг тухай бүрт хуралдуулна.
- 2.3 Гишүүдийн олонхийн ирц бүрдсэнээр удирдах хорооны хурал хүчин төгөлдөр болно.
- 2.4 Асуудлыг хуралд оролцогсдын олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 2.5 Хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг 3-5 хоногийн өмнө гишүүдэд мэдээлж, товыг зарлана.

Гурав. Эрх

- 3.1 Харьяа байгууллагуудаас дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг гаргуулах,
- 3.2 ДЭМБ болон бусад олон улсын төрийн ба төрийн байгууллагаас мэдээлэл хүсэх,
- 3.3 Удирдах хорооны хурлын шийдвэрийг шаардлагатай үед холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх,
- 3.4 Хурлаас гарсан тэмдэглэл, зөвлөмжийн хэрэгжилттэй танилцах биелэлтийн тайланг гаргуулах,
- 3.5 Шаардлагатай асуудлыг зохих журмын дагуу удирдлага, дээд шатны байгууллагад тавих,

Дөрөв. Үүрэг

- 4.7 Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах,
- 4.8 Хамтран ажилладаг байгууллага, хүмүүсийг хуралд урилгаар оролцуулан мэдээлэл хийлгэж хэлэлцэх,
- 4.9 Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэж, дүгнэлт хийх, зөвлөмж гаргах
- 4.10 Дэд хөтөлбөртэй холбоотой гарсан шинэ санаа, туршлага, шинэ технологийг түгээхэд дэмжлэг үзүүлэх
- 4.11 Шийдвэрлэвэл зохих асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгаж шийдвэрлүүлэх
- 4.12 Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан ЭМЯ-ны удирдлагын зөвлөлд танилцуулж санал, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.



Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 09 сарын 20 өдрийн
350 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

**Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн
салбар хорооны удирдах бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн дарга: Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга

Орлогч дарга : Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Нарийн бичгийн дарга: Хавдар судлалын кабинетын их эмч

Гишүүд:

- Дотрын эмч
- Хүүхдийн эмч
- Өрхийн эмч
- Дүн бүртгэгч их эмч
- Хавдрын бүртгэлийн ажилтан
- Эмэгтэйчүүдийн эмч
- Мэс заслын эмч
- Хөнгөвчлөх эмчилгээний эмч